


Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны 06 дугаар сарын 17-ны
өдрийн 9 дүгээр хуралдааны 9/15 дугаар
тогтоолын хавсралт



**ХОВД АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ШАШНЫ БАЙГУУЛЛАГА, СҮМ ХИЙД
БАЙГУУЛАХ, ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ
ТАВИХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийг Ховд аймгийн хэмжээнд хангуулж, иргэд шашин шүтэх эрхийнхээ дагуу сүм хийд шинээр байгуулах, тэдгээрт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийн хугацааг сунгах болон шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Ховд аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага, сүм хийд байгуулах, зөвшөөрлийн хугацаа сунгах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн акт болно.

Хоёр. Сүм хийд шинээр байгуулах

2.1.Шашны байгууллага, сүм хийд шинээр байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дараах бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ирүүлэх ба аймгийн ИТХ-ын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Үүнд:

2.1.1.Шашны байгууллага, сүм хийд байгуулах үндсэн зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тодорхойлсон албан хүсэлт;

2.1.2.Шаардлагыг бүрэн хангасан шашны байгууллагын дүрэм. Дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

- 1/ Сүм хийдийн оноосон нэр, хаяг;
- 2/ Шашны харьяалал, төрөл, урсгал;
- 3/ Тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүд, тэдгээрийн мэдээлэл, бүтэц;

4/ Үйл ажиллагааны хамрах хүрээ, хэлбэрийг тодорхой тусгах. Харин шашны зан үйл г.м. зүйлийг тусгахгүй байх;

5/ Шашин номын хэрэгслэлийн хангамжийн байдал;

6/ Үйл ажиллагаа явуулах, өргөжин бэхжих хөрөнгө санхүүгийн бодит боломж, анхдагч хөрөнгийн хэмжээ;

7/ Хуулийн этгээд болох үндэслэл;

8/ Бусад зүйл.

2.1.3.Шашны байгууллага, сүм хийдийг үүсгэн байгуулж буй иргэдийн дэмжиж гарын үсэг зурсан хамтын шийдвэр, хурлын тэмдэглэл, хуралд оролцогчдын дэлгэрэнгүй мэдээлэл;

2.1.4.Шашны байгууллага, сүм хийд үүсгэн байгуулагч удирдах зөвлөл, тэргүүн, тэдгээрийн дэлгэрэнгүй анкет, боловсрол эзэмшсэн эсэхийг гэрчлэх баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байх, мөн бусад ажилчдын дэлгэрэнгүй анкет,бүртгэл, тухайн ажил албанд томилогдсон шийдвэр гаргасан байх;

2.1.5.Шашны байгууллага, сүм хийдийн зорилго чиглэл, шашны номлол, урсгалын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим шүтэн бишрэгч, итгэгч, сүсэгтэн олонд чиглэсэн ажлын гол агуулга, гадаад харилцааг тодорхой тайлбарласан тайлбар танилцуулга, шашны үйл ажиллагаагаа явуулах тухайн нутаг дэвсгэрийн багийн Иргэдийн нийтийн Хурлын бичгээр өгсөн санал дүгнэлтийг ирүүлэх;

2.1.6.Үйл ажиллагаа явуулах байршил, нутаг дэвсгэр, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ /газар, барилга гэх мэт/, хэрэв түрээсийн байранд байрладаг бол түрээсийн гэрээ, үндсэн хөрөнгийн үнэлгээ зэргийг бүрдүүлэн нотариатаар баталгаажуулсан байх бөгөөд шашны зан үйл явуулах орчин үеийн нөхцөл шаардлага хангасан байр танхимтай байна.

2.1.7.Шашны байгууллага, сүм хийдийн зорилго чиглэл, шашны номлол, урсгалын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, итгэгч, сүсэгтэн олонд чиглэсэн ажлын гол агуулга, гадаад харилцааг тодорхой тайлбарласан танилцуулга;

2.1.8.Шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар бусад шашны хэрэгслийн жагсаалт гаргаж ирүүлэх;

2.1.9.Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр, түүний хэмжээ, гадаад дотоодын хандив тусламж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүгийн баталгаа, үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй тооцоог гаргаж ирүүлэх;

2.1.10.Улсын бүртгэлийн байгууллагаас олгосон оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас ирүүлсэн байна.

Гурав. Зөвшөөрлийн хугацааг сунгах

3.1.Сүм хийд нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд дараах бичиг баримтыг ирүүлсэн байна. Үүнд:

3.1.1.Зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай албан хүсэлт ирүүлсэн байх;

3.1.2.Шашны байгууллага, сүм хийдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.1.3.Зөвшөөрлийн хугацаанд явуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлан;

3.1.4.Тухайн сум, багийн Засаг даргын тодорхойлолтын эх хувь

3.1.5.Зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах шашны байгууллага, сүм хийдийн тэргүүн, удирдах зөвлөл, үндсэн болон сайн дурын ажилчдын мэдээлэл, хүүхэд, сүсэгтэн итгэгч нарын тоо болон судалгааг жагсаалтаар гаргаж ирүүлсэн байх;

Дөрөв. Шашны үйл ажиллагаа эрхлэх, хугацаа сунгах тухай хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх

4.1.Сүм хийд шинээр байгуулах болон үйл ажиллагааны хугацааг сунгах, нэр өөрчилсөн тухай бичгээр гаргасан албан хүсэлтээ тухайн байгууллагын тэргүүн, албан ёсны ажилтан, төлөөлөгч нь ажлын үнэмлэх эсвэл итгэмжлэлтэй ирж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны шашны асуудал хариуцсан ажилтанд шаардлагатай бичиг баримт, холбогдох материалыг бүртгэлд бүртгүүлэн, гарын үсэг зурж, хүлээлгэн өгнө.

4.2.Шинээр зөвшөөрөл авах, үйл ажиллагааны хугацаагаа сунгуулах, оноосон нэр өөрчилсөн тухай хүсэлт ирүүлсэн шашны байгууллага, сүм хийд холбогдох бичиг баримт, материалыг уг журамд заасны дагуу бүрэн бүрдүүлж өгөх бөгөөд хэрэв дутуу бүрдүүлж ирүүлсэн тохиолдолд шаардлага хангаагүйд тооцно.

4.3.Аймгийн ИТХ-ын дэргэд “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-ийг холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулна.

4.3.1.Уг зөвлөлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар байгуулах бөгөөд ахлагч нь Ажлын албаны ОНИХХ-ийн дарга байна.

4.3.2.“Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” нь хагас жилд нэг удаа хуралдаж шашны асуудлаар баримтлах бодлого, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын талаар хэлэлцэнэ.

4.4.Аймгийн ИТХ-ын дэргэдэх “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:

4.4.1.Шинээр шашны байгууллага, сүм хийд байгуулах тухай хүсэлт гаргасан иргэний материалтай танилцаж, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь заалтын дагуу тухайн нутаг дэвсгэрт шинээр шашны байгууллага, сүм хийд байгуулах шаардлагатай эсэхийг хянан үзэж, газар дээр нь шалгалт хийж, гарсан санал, дүгнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулна.

4.4.2.Шашны байгууллага, сүм хийдийн зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах, оноосон нэр өөрчлөх тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн материалтай танилцаж, явуулсан үйл ажиллагаа, хийгдсэн ажлууд болон бусад асуудлыг хянан үзэж, газар дээр нь шалгалт хийж, гарсан санал, дүгнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулна.

4.5.Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон энэ журмын холбогдох зүйл, заалтад тусгасан шаардлагыг хангасан шашны байгууллага, сүм хийдэд шинээр шашны үйл ажиллагаа эрхлэх болон үйл ажиллагааны зөвшөөрлийг сунгах хугацааг дор дурдсанаар тодорхойлно. Үүнд:

4.5.1.Шинээр шашны үйл ажиллагаа эрхлэх байгууллагад зөвшөөрлийн хугацааг 6 сараар олгоно;

4.5.2.Холбогдох хууль тогтоомжийн дагуу шашны үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй, ямар нэг зөрчилгүй албан ёсны зөвшөөрөлтэй явуулж байсан шашны байгууллага, сүм хийдийн зөвшөөрлийн хугацааг аймгийн ИТХ-ын Хуралдаанаас 1 жилээр сунгана.

4.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан зөвшөөрөл олгох шийдвэр болон бусад баримт бичгийг үндэслэн улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн шашны байгууллагыг байгуулсанд тооцно.

4.7.Шашны байгууллага, сүм хийд дүрэмдээ өөрчлөлт оруулсан тохиолдолд аймгийн ИТХ-д тухай бүр нь албан бичгээр мэдэгдэж тодорхойлолт авч, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр бүлгийн 11.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэнэ. Хэрэв заасан хугацаанд мэдэгдээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

4.8.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага, сүм хийдийн тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гармагц Улсын бүртгэлийн байгууллагад албан ёсоор мэдэгдэж улсын бүртгэлээс хасуулах.

Тав. Шашны байгууллагын хүлээх үүрэг, хориглох зүйл

5.1.Шашны байгууллага, сүм хийд дараах үүрэг хүлээнэ:

5.1.1.Шашны байгууллага, сүм хийд нь Монгол Улсын Хууль, тогтоомж, аймаг, сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;

5.1.2.Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэсэн зарчмыг баримтлан бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтантай ёс зүйтэй, хүндэтгэлтэй харьцаж, хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх;

5.1.3.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг Улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

5.1.4.Үйл ажиллагааны болон холбогдох бичиг баримт, мэдээ мэдээллийг төрийн байгууллагад заасан хугацаанд нь үнэн зөвөөр гаргаж өгөх;

5.1.5.Тухайн шашны байгууллага, сүм хийдийн шугамаар ирж буй гадаадын иргэн болон шашны шугамаар гадаадад суралцаж буй иргэдийн талаарх мэдээллийг тухай бүр аймгийн ИТХ-ын дэргэдэх “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”, Цагдаа, Тагнуулын байгууллагад бичгээр заавал мэдэгдэнэ.

5.1.6.Шашны байгууллага, сүм хийд нь гадна хаягжилт хийсэн байх;

5.1.7.Шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл шинээр авсан иргэд хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн байгууллагад албан ёсоор бүртгүүлэн

гэрчилгээ авч харьяалах нутаг дэвсгэрийн татварын болон нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

5.1.8.Шашны байгууллага, сүм хийд нь дүрэмдээ өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр нь “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-д холбогдох материалын хамт албан бичгээр мэдэгдэнэ. Холбогдох материалд:

а/ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

б/ шинээр баталсан дүрмийн хуулбар тус тус байна.

5.1.9.Шашны байгууллага, сүм хийд нь шашны болон хүмүүнлэгийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайлан, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж ажилласан тухай мэдээлэл, холбогдох баримтуудыг “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-д жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх

5.2.Шашны байгууллага, сүм хийдэд дараах зүйлсийг хориглоно:

5.2.1.Аймгийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь зөвхөн тухайн зөвшөөрөл авч буй нэг шашны байгууллага, сүм хийдэд хамаарах бөгөөд нэг зөвшөөрлөөр өөр шашны байгууллага эсвэл ижил урсгалтай салбар, цуглаан, сүм хийд давхар үйл ажиллагаа явуулах,

5.2.2. Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн хаяг, байршлаас өөр байршилд үйл ажиллагаа явуулах, өөр газар, нутаг дэвсгэрт шинээр барилга, байгууламж барих;

5.2.3.Үйл ажиллагааны зөвшөөрөлгүй, мөн зөвшөөрлийн хугацааг хэтрүүлэх, сунгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулах;

5.2.4.Шашны байгууллага, сүм хийдүүд нь төрийн байгууллага, албан тушаалтантай эрх бүхий этгээд буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан харилцах ба сүм хийдийн итгэгч, сүсэгтэн нараас гадна төрийн аливаа байгууллагын албан тушаалтныг харилцаанд оруулах.

5.2.5.Аливаа шашны байгууллага, сүм хийд, лам санваартан иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулах, өөрийн шашныг эс шүтэгчдэд үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд зүйлс үйлчилгээ, мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэх, иргэдийн сүсэг бишрэлийг ашиглан хууль бусаар ашиг орлого олох үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.6.Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, иргэдийн ёс заншил, үндэсний онцлогт харшилсан аливаа үйл ажиллагаа явуулах;

5.2.7.Сүм хийдээс төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэхгүй бөгөөд төрийн эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулах, түүнд оролцох, санхүүжүүлэх;

5.2.8.Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дүрэм, дотоод журмаа чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулах;

5.2.9.Нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий, гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, шашны зан үйл, бусад үйл ажиллагаа зохион байгуулах;

5.2.10.Шашны байгууллага, сүм хийд нь өөрийн шашны номлол,үзэл суртлыг бага насны хүүхдэд түүнчлэн цэцэрлэг, сургууль, олон нийтийн газарт тэдний эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн хараа хяналтгүйгээр шашны ямар нэгэн үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй хүнийг шашны ямар нэгэн арга хэмжээнд татан оролцуулах, үзэл номлолоо хүчээр тулгах, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг нь үймүүлэх;

5.2.11.Шашны байгууллага, сүм хийд нь дэргэдээ аливаа хэлбэрийн сургалтын байгууллага, дотуур байр ажиллуулах

5.2.12.Шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагааг зогсоосон, зөвшөөрлийг цуцалсан үед ямарваа нэгэн арга хэмжээ, шашны цуглаан зохион байгуулах.

5.3.Шашны байгууллага, сүм хийдэд 16 наснаас доош насны хүүхдийг шашны ямар нэгэн номлол сургаалд хамруулах болон шавилуулах бол тэдний харгалзагч, эцэг эхийн хүсэлтийг бичгээр гаргуулан авч шийдвэрлэнэ.

5.4.Хуульд заасны дагуу өөрийн хүсэлтээр шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ тухайгаа “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-д 7 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

Зургаа. Шашны байгууллага, сүм хийдийн үйл
ажиллагаанд хяналт тавих

6.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” нь шашны байгууллага, сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулна.

6.2.Хяналт шалгалтыг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

6.2.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийх;

6.2.2.“Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-ийн санаачилгаар төлөвлөгөөт бус гэнэтийн хяналт шалгалт хийх;

6.2.3.Сүм хийд аливаа шашны байгууллагын талаар иргэдээс ирүүлсэн санал гомдол, хүсэлтийг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллагатай хамтран шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргуулна.

6.3.“Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” нь шашны байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, журмын хэрэгжилтийг хянан шалгана. Үүнд:

6.3.1.Улсын бүртгэлийн гэрчилгээ, газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний эх хувь;

6.3.2.Санхүүгийн бичиг баримт /санхүүгийн эх үүсвэр болон орлого, зарлага/;

6.3.3.Шашны байгууллагаас аливаа хуулийн этгээд, иргэнтэй хийсэн гэрээний эх хувь;

6.3.4.Гадаад улсын шашны болон олон улсын байгууллагатай хамтран ажилладаг бол тэр тухай албан ёсны бичиг баримт /Хамтран ажиллах санамж бичиг, гэрээ, шийдвэр/ зэргийг баталгаат орчуулгын товчоогоор Монгол хэлэнд хөрвүүлж, нотариатаар баталгаажуулсан байх;

6.3.5.Шашны байгууллагын бүртгэл судалгааг /Удирдах болон гүйцэтгэх ажилтнууд, итгэгч, сүсэгтэн олон, бага насны хүүхэд гэх мэт/ үндсэн баримт материалтай тулгах.

6.4.“Шашны асуудал эрхэлсэн зөвлөл” нь хяналт шалгалтын үед илэрсэн зөрчил, дутагдлыг тухайн шалгуулагч этгээд, түүний албан ёсны төлөөлөгчид мэдэгдэж, шаардлагатай бол тайлбар гаргуулан авна.

6.5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дахин ижил төрлийн зөрчил дутагдал гаргуулахгүй байх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохих мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлж болно.

Долоо. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг цуцлах, зогсоох

7.1.Шашны байгууллага, сүм хийдүүд нь үйл ажиллагаагаа өөрийн хүсэлтээр зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ тухайгаа “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-д албан бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

7.2.Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын зүйл, заалтыг зөрчсөн мөн Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, иргэдийн зан заншил, үндэсний онцлогт харшилсан, иргэдийн сүсэг бишрэлийг далимдуулан тэдний оролцоог ашиглан аливаа хууль бус ашиг, орлого олоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа нь тогтоогдсон тухай хууль хяналтын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн тухайн шашны байгууллага, сүм хийдэд олгосон зөвшөөрлийг цуцалж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй тохиолдолд холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

Найм. Хариуцлага

8.1.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аливаа шашны байгууллага, сүм хийд нь энэ журмын 5 дугаар бүлгийн 5.2.1-ээс 5.2.12 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг цуцалж, шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

---- ооОоо ----